

**БАТЛАВ.**  
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ  
ДЭРГЭДЭХ МЭДЭЭЛЛИЙН  
ТЕХНОЛОГИЙН ТӨВИЙН ЗАХИРАЛ



Ж.ЭРДЭНЭБАТ

**БАТЛАВ.**  
УЛААНБААТАР ХОТ  
ВЕРТЕКС МОН ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ш.НАРАНЦОГТ

### ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

2016 оны 03 дугаар  
сарын 24 ны өдөр

Дугаар УИХ-08

Улаанбаатар  
хот

#### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.7 дахь хэсэг, Иргэний хуулийн 243-261 дүгээр зүйлийг баримтлан энэхүү гэрээг нэг талаас захиалагч 9128719 регистрийн дугаартай Сонгуулийн ерөнхий хороо /цаашид захиалагч гэх/-г төлөөлж Мэдээллийн технологийн төвийн Техник, үйлчилгээний хэлтсийн дарга Б.Батсайхан, нөгөө талаас Вертекс Мон ХХК /цаашид гүйцэтгэгч гэх/-ийг төлөөлж борлуулалтын албаны дарга Д.Мэндсайхан нар дор дурдсан нөхцөлийг харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

1.2. Сонгуулийн ерөнхий хороонд Cisco RV042 Dual WAN VPN Router төхөөрөмж нийлүүлэх, хүлээн авахтай холбогдох үйл ажиллагааг зохицуулахад энэхүү гэрээний зорилго оршино.

#### Хоёр. Захиалагчийн эрх, үүрэг

2.1. Сонгуулийн Ерөнхий Хороо Cisco RV042 Dual WAN VPN Router төхөөрөмжийн тоо, хэмжээ, загвар, үзүүлэлтийг 2016 оны 03 сарын 24-ний дотор гаргаж өгнө.

2.2. Cisco RV042 Dual WAN VPN Router төхөөрөмжийг нийлүүлэх явцад захиалагчийн зүгээс хянах, зөвлөх эрх бүхий хүн ажиллуулна.

2.3. Барааг чанар, шаардлагын дагуу захиалагч хүлээн авмагц төлбөрийг гэрээнд заасны дагуу саадгүй төлнө.

#### Гурав. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

3.1. Cisco RV042 Dual WAN VPN Router төхөөрөмж 31 ширхэгийг шаардлагын дагуу нийлүүлж 2016 оны 03 сарын 25-ны дотор захиалагчид хүлээлгэж өгнө.

3.2. Cisco RV042 Dual WAN VPN Router төхөөрөмжийг хавсралтанд дурдсан тоо, хэмжээ, загвар, үзүүлэлттэй нийлүүлнэ. Тогтоосон тоо, хэмжээ, загвар,

үзүүлэлтээс өөр, хугацаа хожимдуулсан тохиолдолд өөрийн зардлаар хохирлыг арилгаж хариуцлага хүлээнэ.

3.3. Ажлын чанар, үр дүнд муугаар нөлөөлөхөөр, гүйцэтгэгчээс үл хамаарах ямар нэгэн нөхцөл байдал бий болсон тохиолдолд захиалагчид нэн даруй мэдэгдэнэ.

3.4. Чанарын шаардлагад нийцээгүй бараа нийлүүлсэн тохиолдолд тогтоосон хугацаанд өөрийн зардлаар нөхөн нийлүүлнэ.

3.5. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9 дэх хэсэг, Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журмын 19 дүгээр хавсралтын дагуу гаргасан мэдээллийг Сонгуулийн Ерөнхий Хорооны цахим хуудас, мэдээллийн самбарт заавал байршуулна.

#### Дөрөв. Төлбөр тооцоо

4.1. Cisco RV042 Dual WAN VPN Router төхөөрөмж нэг бүрийг 310,000 төгрөгөөр нийлүүлж Сонгуулийн ерөнхий хороонд хүлээлгэж өгсний дараа төлбөрийг Вертекс Мон ХХК -ийн Худалдаа Хөгжлийн банкны 452575275 тоот дансанд ажлын 3 хоногт багтаан шилжүүлнэ. Регистрийн дугаар: 5602513

№	Төрөл	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Cisco RV042 Dual WAN VPN Router төхөөрөмж	31	310,000	9,610,000
	Дүн			9,610,000
	НӨАТ 10%			961,000
	<b>НИЙТ ДҮН</b>			<b>10,571,000</b>

ТӨРИЙН  
МЭРГЭЖИЛТЭН

4.2. Нэмэгдсэн өртгийн албан татварыг гүйцэтгэсэн ажлын нийт үнийн дүнгийн 10 хувиар захиалагч тал төлнө.

#### Тав. Бусал зүйл

5.1. Захиалагчийн буруутай үйлдлээс шалтгаалж загвар, тоо хэмжээг өөрчилсөн зэргээс үүдэн гарах хариуцлагыг захиалагч өөрөө хүлээнэ.


5.2. Хугацаа хожимдуулсан, чанарын гологдол, алдаа гаргасан, загварын дагуу хийгдээгүй зэрэг шалтгаанаас учирсан хохирлыг гүйцэтгэгч хариуцна.

5.3. Энэхүү гэрээ нь хоёр тал гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс хүчин төгөлдөр болно.

5.4. Маргаантай асуудлыг хоёр тал хариуцан тохиролцож шийдвэрлэх ба эс тохиролцвол шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:


Мэдээллийн технологийн төвийн  
Техник, үйлчилгээний хэлтсийн дарга



**Б.БАТСАЙХАН**

**Хаяг:** Улаанбаатар хот – 38  
Ж.Самбуугийн гудамж – 11  
Засгийн газрын 11 дүгээр байр  
2 дугаар давхар  
Сонгуулийн Ерөнхий Хороо  
**Утас:** 51-62262117

Вертекс Мон ХХК -ийн  
Борлуулалтын албаны дарга



**Д.МЭНДСАЙХАН**

**Хаяг:** Улаанбаатар хот, СБД,  
5-р хороо,  
Үндсэн хуулийн гудамж,  
Cisco-mall дэлгүүр  
Вертекс Мон ХХК  
**Утас:** 75750700, 70000701

Сонгуулийн ерөнхий хорооны  
2016 оны Худалдан авах <sup>УИТ-08</sup> дугаар  
гэрээний 1 дүгээр хавсралт

**CISCO RV042 DUAL WAN VPN ROUTER ТӨХӨӨРӨМЖ**

Брэнд	- Cisco
Загвар Үзүүлэлт	- Cisco RV042 Dual WAN VPN Router - WAN Ports: 2x10/100 Mbps - LAN Ports: 4x10/100 Mbps - VPN: Full IPSec VPN Capability using DES and 3DES Encryption Algorithms - Support for MD5 and SHA Authentications Algorithms - Create up to 30 simultaneous IPSec VPN Tunnels - DMZ Ports: 1x10/100 Mbps RJ-45 port - Throughput: 200Mbps Cisco RV042 Dual WAN VPN Router
Нэмэлт шаардлага	- Шинэ байх
Баталгаат хугацаа	- 12 сар
Нийлүүлэх хугацаа	- 3 хоног
Тоо хэмжээ	- 31
Нэгжийн үнэ	- 310,000 төгрөг /НӨАТ ороогүй/

Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга,  
нийтлэг стандартыг тогтоох журмын 19 дүгээр хавсралт

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 10 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий  
ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн талаарх улирлын мэдээлэл

						(төгрөгөөр)
№	Гүйцэтгэгчийн нэр	Тухайн жилд нийлүүлсэн бараа, ажил үйлчилгээний нэр	Гэрээний дүн	Хэрэгжилтийн явц (өссөн хувиар)	Тухайн ажил, үйлчилгээг гүйцэтгэхэд гаргасан зардал (өссөн дүнгээр)	Төсвөөс олгосон санхүүжилт (өссөн дүнгээр)
1	ВЕРТЕКСМОН ХХК	Cisco RV042 Dual WAN VPN Router төхөөрөмж нийлүүлэх	10.571.000.00 ₮	100%	-	10.571.000.00 ₮



Мэдээлэл гаргасан: ...../Д.Мөндсайхан/  
ХӨРЛӨӨЛӨЛТӨН АЛБАНЫ ДАРГА